

Хариу тайлбар хүргүүлэх тухай

Хяналтын зөвлөлийн 2023 оны 9 дүгээр сарын 14-ний өдрийн 1/23 тоот албан бичгийн хавсралтаар ирүүлсэн Коёото ХХК-ийн захирал Д.Бямбасайхан, Алтан Дорнод Монгол ХХК-ийн захирал Ц.Оюунцацралт, Эм Си Эй ХХК-ийн захирал Э.Оюунтэгш нарын гаргасан холбогдох гомдолтой МҮХАҮТ-ын Ерөнхийлөгч О.Амартүвшин, гүйцэтгэх захирал Т.Дүүрэн нар танилцаж, дараах хариу тайлбарыг хүргүүлсэн.

Энэхүү гомдолд тавьсан асуудлууд нь ам дамжсан яриа таамагт үндэслэсэн, зарим нь гүтгэлгийн шинжтэй, цаг үетэйгээ нийцүүлэн хийсэн шинэчлэл өөрчлөлт болон МҮХАҮТ-ын удирдлага, хамт олны хичээл зүтгэл, ажлын үр дүнг үгүйсгэсэн байгааг Хяналтын зөвлөлийн гишүүд анхаарч үзэхийг хүсье.

Хяналтын зөвлөлөөс тавьсан шаардлагын дагуу гомдлын асуудал тус бүрээр хариу тайлбарыг зарим нотлох баримтын хамт бэлтгэн хүргүүлж байна.


- 1. Самрын экспортлогч компаниудад гарал үүслийн гэрчилгээ олгохгүй удааж, компаниудаас авилгал хээл хахууль авсан байж болзошгүй.*

Самрын экспорт нь 2020 оныг хүртэл хууль зөрчсөн далд хэлбэрээр, ААНОАТ, НДШ төлдөггүй байдлаар явж ирсэн. Үүнд танхимын гишүүн дотоодын үйлдвэрлэгч нар эсэргүүцэл илэрхийлж хүсэлт гаргасны үндсэн дээр судалгаа хийж, Европын холбооны ТРАМ төсөлтэй хамтран бие даасан “Самрын кластер” ТББ байгуулж, самрын компаниуд нь өөрсдөө тэр ТББ-ынхаа үүсгэн байгуулагч болж Монгол улсад төлөх ёстой татварыг Хятадын талаас урьдчилан төлүүлэх нөхцлийг бүрдүүлсэн. Захиран зарцуулах эрх нь компаниудад байсан ба хяналтын зорилгоор МҮХАҮТ 1 саналын эрхтэйгээр орж байсан. Гэвч хятадын талын компаниудад уг санал таалагдаагүй тул энэхүү зохицуулалтыг цуцалсан. Ийм төрлийн хууль бус экспортыг мөн оффшор мөнгө угаах ажиллагаанд ашигладаг талаар судалгаа дүгнэлтийг гаргаж Үндэсний Аюулгүй Байдлын Зөвлөлийн гишүүдэд албан ёсоор танилцуулсан болно.

Үүний дараа БНХАУ-ын ЭСЯ болон Бээжинд төвтэй дэлхийн 50 улсын үүсгэн байгуулсан Олон Улсын Худалдааны Маргааныг Зохицуулах, Урьдчилан Сэргийлэх байгууллага ICDPASO (Монгол улс нэгдэж орсон гишүүн нь) аар дамжуулан хэлэлцээр хийх болсон. Үүнд Монголын талаас хятадын ченжүүдийг борлуулалтаа 100% ил тод болгох шаардлага тавьсан. Харин нөгөө талаас, нэг

дор бус, шат дараатайгаар 2028 он хүртэл ил тод болгох санал тавьсныг эцэст нь бид хүлээж авсан. Энэ бүх хэлэлцээр цахимаар, ил тод хийгдэж, хэвлэл мэдээллээр цацагдсан. Гэвч 2022 оны 11 сарын 15-ны өдөр Эдийн засаг хөгжлийн яамны сайдаас өгсөн чиглэлийн дагуу уг хэлэлцээрийг зогсоож Монголын компаниуд шаардлагаасаа ухарсан юм. Одоо самрын экспорт хуучин аргаараа далд бүртгэлтэйгээр өрнөж байгаа бөгөөд нэг ёсондоо бидний шаардлага хангагдаагүй. Тухайн Маргааныг зохицуулах байгууллага нь Хятад дотроо үйлчилгээний хөлсөө хэрхэн тогтоосон нь тэдний өөрсдийн эрх мэдлийн хэрэг юм. Энэ бүхний дүнд тодорхой үр бол гарсан. Бүртгэл 50% ил тод болох нөхцөл бүрдсэн.

Зураг 1: Самрын экспортын тоо хэмжээ, сая доллараар



Бодит байдал дээр нийт борлуулалт ойролцоогоор 150-200 сая ам.долларт хүрч байгаа гэсэн тооцоолол бий. Өнөөдрийн байдлаар дэлхийн зах зээлийн үнэ 16-20 ам.доллар дээр буй ч, бүрдүүлэлт хийхдээ үнийг 7-8 ам.доллар гэж дарж мэдүүлж байна.

2. Махны гарал үүслийн гэрчилгээний хүнд суртал

МҮХАҮТ нь гарал үүслийн гэрчилгээг бүх шатандаа түргэн шуурхай, хүнд сурталгүй олгох тал дээр анхаарч ажилладаг. Гарал үүслийн гэрчилгээ олгож байх хугацаанд мах экспортлогч ААН-үүдээс энэ талаар асуудлыг тавьж байгаагүй. Түүнчлэн махны гарал үүслийн гэрчилгээг 2020 онд ХХААХҮЯ-аас санаачилсан мах экспортлогч ААН-үүдэд төрийн үйлчилгээг хүндрэлгүй, нэг дороос хүргэх зорилгоор хэрэгжүүлсэн “Нэг цэгийн үйлчилгээ”-нд МҮХАҮТ-ын мэргэжилтэн ХХААХҮЯ дээр байрлан, гарал үүслийн гэрчилгээг олгож байсан.

МҮХАҮТ-ын санаачилгаар ХХААХҮЯ-ны 2022 оны "Ажлын хэсэг байгуулах тухай" А/372 дугаар тушаалын хүрээнд мах, махан бүтээгдэхүүний экспортын үйл ажиллагааг цахимжуулах ажлыг хэрэгжүүлж, хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний экспортын нэг цонхны системийг 2023 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн нэвтрүүлэн хамтран ажиллаж байна.

3. Их хуралд оролцох эрхтэй компаниудын жагсаалтад нэр дэвшигчид, танхимын гишүүд хяналт тавих боломжгүй байна.

МҮХАҮТ-ын хууль, дүрэмд МҮХАҮТ-ын гишүүн нь сайн дурын үндсэн дээр элссэн, холбогдох хуулийн дагуу байгуулагдсан дотоод, гадаадын аж ахуйн нэгж, байгууллага, иргэн байна гэж заасан байдаг. Өнөөдрийн байдлаар Үндэсний танхим нь нийт 5956 гишүүн байгууллага бүртгэлтэй байгаа бөгөөд Улаанбаатар хотод 2516 орон нутгийн салбар танхимуудад бүртгэлтэй 3440 аж ахуйн нэгж, байгууллага, хувь бизнес эрхлэгч бүртгэлтэй байна.

Хэдийгээр гишүүн 2 жил дараалан гишүүний татвараа төлөөгүй буюу МҮХАҮТ-ын дүрмийн 4,2,6. 4,2,10-д заасан үүргээ биелүүлээгүй бол гишүүнээс чөлөөлөх заалттай. Хэдий ч өнөөдрийг хүртэл бид нэг ч байгууллагыг гишүүнээс хасалгүй мэдээлэл үйлчилгээгээ үзүүлсээр ирсэн. МҮХАҮТ-ын Удирдах зөвлөлийн 2023 оны 8 дугаар сарын 10-ны өдрийн хуралдаанаар XXI ээлжит их хурлын товыг тогтож хуралд оролцох гишүүн байгууллагуудад нээлттэй мэдээлэл хүргүүлж гишүүдийн бүртгэлийг 2023 оны 09 сарын 15-ны өдрийг хүртэл хийж хуралд оролцох гишүүдийг тоог эцэслэн гаргасан болно.

МҮХАҮТ-ын XXI их хуралд гишүүний ямар нэгэн зөрчилгүй, татвар хураамжаа цаг хугацаанд нь төлсөн гишүүд оролцох зохицуулалттай.

МҮХАҮТ-ын Trademongolia.mn веб сайт дээр үндэсний танхимын хэмжээнд бүртгэлтэй нийт гишүүдийн ерөнхий мэдээлэл, үйл ажиллагааны чиглэл, салбарын ангиллын дагуу нээлттэй байршсан байдаг.

Их хурлаас сонгогдсон хяналтын зөвлөл танхимын үйл ажиллагаанд хяналт тавих бүрэн эрх нь нээлттэй бөгөөд гишүүнчлэлийн нэгдсэн ПОРТАЛ сайтаас гишүүдийн ангилал, төлбөрийн мэдээллийг татаж харах, тайлан хэлбэрээр харах боломжтой юм. Портал сайтын хувьд Санхүү бүртгэлийн газар болон холбогдох банкны системүүдтэй холбогдсон байдаг бөгөөд гишүүнчлэлийн хугацаа дуусмагц систем автоматаар гишүүн байгууллагуудад төлбөрийн нэхэмжлэл илгээдэг загварчлалтай юм.

Жил бүр санхүүгийн аудит орж бидний үйл ажиллагаанд хяналт тавьж, зааварчилгаа өгч ажилладаг. Бид гишүүнчлэлийн бүртгэл, төлбөр хураамжийн мэдээллийг цаг тухай бүрд нь гаргаж өгч байсан болно.

Аливаа байгууллагын дотоод үйл ажиллагаанд хэн дуртай хүн хяналт тавих эрхгүй бөгөөд энэ нь тодорхой хуулиар зохицуулагдсан байдаг учир нийтэд ил болгох боломжгүй болно. Дээрээс нь сайн дурын гишүүнчлэлтэй учир Танхимын зүгээс гишүүнчлэлийн төлбөр хураамжаа заавал төл гэсэн шаардлага тавьдаггүй. Гишүүн байгууллагын өмнөөс өөр хэн нэгэн төлбөрийг нь төлөх боломжгүй бөгөөд банкны систем, тухайн байгууллагын регистрийн дугаар, портал сайтаас үүсэж буй нэхэмжлэлийн дугаарууд хоорондоо тохирч байх ёстой юм.

21 дүгээр их хуралд оролцох гишүүн байгууллага түүний төлөөлөл нь тухайн аж ахуйн нэгжийн гүйцэтгэх удирдлага, ажилтан гэдгээ баталгаажуулах, итгэмжлэгдсэн төлөөлөгч бол тухайн байгууллагаас тусгайлан итгэмжлэл авч оролцох тул хэн дуртай хүн оролцох боломжгүй.

4. Арбитрыг хувьдаа авч тусад нь гаргаж болзошгүй байна.

Бизнесийн маргааныг шийдвэрлэх хууль эрх зүйн орчныг сайжруулах, түүний үр өгөөжийг дээшлүүлэхийн тулд арбитрын эрх зүйг боловсронгуй болгох, Монголын Олон улсын Арбитрийг институцийн хувьд бэхжүүлэх, чадавхийг сайжруулах, хараат бус байдлыг хангахад анхаарч ажилласан. Өмнө нь танхимын дарга эсвэл ерөнхийлөгч нь арбитрийн даргын үүргийг давхар хашиж байсныг энэ удаад өөрчилсөн. МҮХАҮТ-ын дүрэмд заасны дагуу Улаанбаатар хотын ХАҮТ-ын дэргэдэх арбитрийн дарга, Хууль Зүйн Үндэсний Хүрээлэнгийн захирлын алба хашиж байсан С.Энхцэцэгийг МҮХАҮТ-ын Удирдах Зөвлөлийн 2019 оны 3 дугаар сарын 15-ны хурлаар санал болгож, УЗ-ийн дугаар 13 тогтоолоор МОУА-ын даргаар томилуулсан. Мөн арбитрийн нэрийг УЗ-ийн 2019 оны 7 дугаар сарын 4-ний хурлын дугаар 16 тогтоолоор өөрчилсөн болно. МҮХАҮТ-ын дүрмийг Арбитрыг тусад нь авч гарах боломжгүй. *(Хавсралт 1)*

5. Экспертизийн үйлчилгээг үгүй хийж хуучин өрсөлдөгч компанид нь өгч байна.

Итгэмжлэл, баталгаажуулалтын үйлчилгээний салбарт сүүлийн 10-аад жилд хувийн хэвшлийн байгууллагууд, тэр дундаа олон улсын хэмжээнд ажилладаг компаниудын салбарууд орж ирэх болсон бөгөөд аж ахуйн нэгжүүдийн хувьд үйлчилгээний сонголт хийх өргөн боломжтой болсон. Иймээс танхимын экспертизийн үйлчилгээг цаашид сайжруулах, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх асуудлыг судлан үзэж, боломжийн талаар саналыг Тэргүүлэгчдийн 2023 оны 3 дугаар сарын 15-ны хуралд танилцуулан дугаар 04 тогтоолоор чиглэл авсан бөгөөд одоогоор Амбер болон өөр бусдад шилжүүлэх ямар нэг шийдвэр гараагүй болно. *(Хавсралт 2)*

6. “Дэлхийн Экспо”-д оролцуулахаар 100 хүний зардлыг Арабын Нэгдсэн Эмират Улсын Засгийн Газраас даана гэсэн эрхийг ашиглаж өөрсдийн ах дүү, найз нөхөд, UFC группынхээ хүмүүсийг “зугаалуулсан”

Дэлхийн экспо бол 100 гаруй жилийн түүхтэй, дэлхийн улс орнууд өөрсдийн хөгжил, хандлагаа дэлхийд танилцуулах 5 жил тутамд нэг удаа зохион байгуулагддаг, Засгийн газруудын түвшний арга хэмжээ билээ. ХАҮТ-ын тухай хуулийн 4.4 зүйлд заасны дагуу Танхим уг экспод засгийн газрыг дэмжин туслан хэрэгжүүлэгчээр оролцдог. АНЭУ-ын Дубай хотод зохион байгуулагдсан “ЭКСПО 2020” 2021 оны 10-р сарын 1-ээс 2022 оны 3 дугаар сарын 31 дуустал хугацаанд үргэлжилсэн. Уг үзэсгэлэнгийн үндсэн зохион байгуулагчаар нь Гадаад харилцааны яам, хамтран зохион байгуулагчаар нь МҮХАҮТанхим ажилласан.

2021 оны 1 дүгээр сарын 20-нд ирүүлсэн АНЭУ-ын олон улсын оролцогчдыг хариуцсан дарга Омар Шехадехийн албан бичгээр павильонд ажиллах ажилчдын амьдрах байр, нисэх агаарын тийзийн зардлыг даасан бөгөөд үндэсний өдрөөр соёл урлагийн тоглолт хийх тоглох 10 хүн, 2 хариуцах хүний зардлыг даасан болно.

Экспогийн зардлын төсвийг Засгийн газар хянаж баталдаг ба цаад талын болон Монгол улсын зардлаар оролцох урлаг соёлын баг, төр засгийн төлөөллийн зардлыг ГХЯ сонгон, хянаж илгээдэг. Бүх харилцаа ГХЯамаар дамждаг тул Танхим үүнээс далдуур нууцаар зохион байгуулах боломжгүй юм. Дэлхийн Экспо 2020 Дубай хувьд энэ үеэр МИАТ компани чартер нислэг үйлдэж, аялал

жуулчлалын бүтээгдэхүүн үүсгэж, Танхим нь гишүүн компаниудад зар түгээсэн. Гишүүн компаниудын ажилтнууд өөрсдийн зардлаар зорчсон. Төрийн болон бизнесийн байгууллагууд өөрсдөө зардлаа даан үндэсний өдөр болон бизнес форумд оролцсон болно. Үүнийг чартер нислэг хийсэн компаний санхүүгийн баримтаас мэдэх боломжтой.

7. Сургалтын үйлчилгээг найздаа өгсөн, Танхимын нэр хүндийг хувьдаа ашиглаж байгаа байдал

2019 оны байдлаар Бизнес Академи нь дараах сургалтуудыг явуулдаг байсан:

- Гадаад худалдааны менежер бэлтгэх 1 жилийн сургалт 2019-2020
- Санхүүгийн менежер бэлтгэх 1 жилийн сургалт 2019-2020
- Компанийн засаглалын сургалт

2020-2021 онд хичээлийн жилийн сургалтуудыг зарлаад оюутнууд бүртгэсэн байсан боловч сургалтын материал байхгүй, хичээл заах багш нартай гэрээ хийж тохиролцоогүй бөгөөд өмнөх сургалтын үйл ажиллагаанаас орох орлого, урсгал зардлаа нөхөж чадахгүй байдалд байсан.

Иймээс МҮХАҮТ-ын 1000 CEO, 1000 Хүчирхэг компани зорилтыг хангах зорилгоор Бизнес академийн үйл ажиллагааг эрс өөрчилж, үйл ажиллагааг олон улсын стандартад хүргэн ажиллах зорилтын хүрээнд Юнайтед менежмент Консалтинг ХХК-тай хамтын ажиллагааны гэрээ байгуулан ажилласан. Хэн нэгэн хувь хүн, найзыг сонгосон асуудал байхгүй. Уг компани нь:

- Хүний нөөцийн олон улсын үнэлгээ аргачлалыг Монголд анх удаа нэвтрүүлж Францын сэтгэл судлалын нийгэмлэг, Америкийн Сэтгэл судлалын холбоо, Английн Сэтгэл судлалын нийгэмлэг зэрэг олон улсын түвшинд хүлээн зөвшөөрөгдсөн сэтгэл судлалын мэргэшсэн байгууллагуудын оюуны чадамжийн сорил, тестийн хэм хэмжээгээр баталгаажсан, олон улсын гишүүн байгууллагын 12 төрлийн тестийг Монголд албан ёсны эрхтэйгээр нэвтрүүлэн Карьер хөгжлийн төв, Хүний нөөцийн үнэлгээний төвийг үүсгэн байгуулсан,
- Дэлхийн шилдэг бизнесийн сургуулиуд, институт Harvard Business Review, MIT Sloan Management Review, MIT Technology Review, Stanford Social Innovation Review, Wharton magazine, Berkeley Haas magazine зэрэг бүс нутаг болон дэлхийд өрсөлдөх чадвартай манлайлагчид, бизнесийн хөгжлийг дэмжих мэдээллийн эх сурвалж болох Бизнесийн сэтгүүл болон Бизнесийн номуудыг албан ёсны эрхтэйгээр эрхлэн гаргадаг /United Business Review/
- Менежмент манлайллын олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн нэр хүнд бүхий сургалтын байгууллагуудтай хамтран ажиллахаар гэрээ хэлцэл хийж байсан /Harvard managementor, UC Berkeley Executive education, Английн захиралуудын институт /,
- Олон улсын хөтөлбөр төслүүдийн менежмент хийдэг хамтын ажиллагаа, туршлагатай /GIZ, Австри Монголын ЗГ хоорондын хөгжлийн төслүүд/, 2016 оны МҮХАҮТ-ын шилдэг Бизнесийн зөвлөх үйлчилгээний оны онцлох энтрепренер байгууллага болсон амжилтын түүхтэй Юнайтед Менежмент Консалтинг ХХК-тай хамтын ажиллагааны гэрээ хийж ажилласан.

Энэ хугацаанд гишүүн байгууллагууд болон бизнес эрхлэгчдэд зах зээлээ өргөжүүлэх, өрсөлдөх чадвараа нэмэгдүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх, мэдлэг мэдээллээр хангах зорилгоор урт болон богино хугацааны сургалт, албан байгууллагын дээрх захиалгат сургалтуудыг цахим болон танхим хосолсон хэлбэрээр зохион байгуулж, 3000 орчим хүнийг сургалт, арга хэмжээнд хамруулсан байна. Үүнд:

- *Харвард менежментор хөтөлбөр:* Харвард бизнесийн сургуулийн Harvard ManageMentor (Харвард МенежМентор) хөтөлбөрийг албан ёсны эрхтэйгээр 2021 онд амжилттай эхлүүлсэн бөгөөд дэлхийн бизнесийн шилдэг боловсролыг эх орондоо эзэмшиж, менежерүүдэд манлайллын ур чадвар, карьераа өсгөх боломж олгож байгаа энэхүү цогц хөтөлбөрийг эх хэлээрээ суралцах нөхцөлийг бүрэн хангаж ажиллаж байна.
- *Бизнесийг эрчимжүүлэх менежментийн хөтөлбөр:* Бизнесийн бүх салбарын жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдэд зориулсан “Ковидын дараах бизнесийг эрчимжүүлэх” менежментийн хөтөлбөрийг “Нийслэлийн жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих төв” НӨҮГ-тэй хамтран хэрэгжүүлж байна.
- *CEO excellence:* “HARVARD BUSINESS SCHOOL” кейс ажиллагаанаас бүрдсэн сургалтын формат, контент, McKinsey & Company-ийн глобал түвшний 2000 гаруй CEO-оос авсан CEO EXCELLENCE судалгааны агуулгаар баяжуулан боловсруулсан CEO-ийн эзэмших ёстой 6 сэтгэлгээ 18 дадлыг эзэмшүүлэх сургалт
- *CEO update:* Гүйцэтгэх захирлуудын суурь чадамжийг хөгжүүлэх, илүү сайн гүйцэтгэлтэй хүчирхэг удирдагч болоход манлайллын ухааны хамгийн сүүлийн үеийн мэдлэг, ойлголтыг богино хугацаанд өгөх замаар захирлуудын тасралтгүй хөгжлийг хангах CEO MINDSET - СЭТГЭЛГЭЭ, CEO KNOWLEDGE - МЭДЛЭГ, CEO SKILLS - УР ЧАДВАР- ыг тодорхойлох 15 үзүүлэлтийн хүрээнд “ЗАХИРЛЫН СУУРЬ ЧАДАМЖ”-ийг хөгжүүлэх, илүү сайн гүйцэтгэл, манлайлалтай хүчирхэг удирдагч болоход чиглүүлэх сургалт
- *Компанийн засаглалын гэрчилгээ олгох сургалт:* Компанийн ТУЗ-ийн гишүүн, нарийн бичиг, удирдах ажилтан, эрх бүхий албан тушаалтан, бусад ажилтнуудад зориулсан Компанийн засаглалын тухай ойлголт, Компанийн тухай Монгол Улсын хууль тогтоомжийн практик хэрэглээний мэдлэг, ур чадвар олгох уг сургалт
- *Менежерийн ахисан түвшний хөтөлбөр:* Хурдтай өөрчлөгдөж буй бизнесийн энэ орчинд байгууллагыг урт хугацаанд тогтвортой байлгахын тулд сэтгэл ханамжтай багийн гишүүн нэг бүрийн гүйцэтгэлийг дээд хэмжээнд нь барих, түүний тулд дасан зохицоход нь туслах, идэвхижүүлэх, дэмжих, зохион байгуулах болон оновчтой зөв шийдвэрээр дамжуулан зөрчлийг багасгаж, гүйцэтгэлийн өндөр түвшинд хүргэж чаддаг манлайлагчийн ур чадварыг олгох сургалт
- *Гадаад худалдааны менежер / экспортын менежер хөтөлбөр:* 2021 онд сургалтын хөтөлбөрийг Олон улсын худалдааны байгууллага /ICT/-ын агуулгад нийцүүлэн онлайн, танхим хосолсон хэлбэрээр агуулгын шинэчлэлт хийж , сургалтын контентийг боловсруулан хүргэж байна. Ковидын дараах зах зээлийн нөхцөл байдал, Монгол улсын засгийн газрын бодлоготой уялдуулан, уул уурхайн бус бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх зорилгод нийцүүлэн зорилтот зах зээлд бараа бүтээгдэхүүн

экспортлоход шаардлагатай бодлогын арга хэрэгслийг зөв ашиглаж, экспортын зах зээлд нэвтрэхэд баримтлах стратеги, шаардлагатай судалгаа хийх арга, аргачлал болоод үйл ажиллагааны замын зураглалыг гаргах, баримт бичгийг бүрдүүлэх ур чадвар эзэмшүүлэх практикт суурилсан “Экспортын менежер” бэлтгэх хөтөлбөрийг боловсруулан хүргэж байна.

- Санхүүгийн менежер хөтөлбөр: Бизнесийн байгууллагын үйл ажиллагааны цөм нь болдог урт хугацаат хөрөнгө оруулалтын шийдвэр гаргалтын арга, техникүүд болон зан төлөвийн санхүүгийн ухагдахуун ойлголтыг эзэмшүүлж, компанийн санхүүгийн менежментийн зохицуулалтыг мэргэшин суралцах хэрэгцээ байгааг харгалзан онлайн, танхим хосолсон хэлбэрээр агуулгын шинэчлэлт хийж, сургалтын контентийг боловсруулан хүргэж байна.

Бусад сургалтууд:

- Ковид-19: хууль эрх зүйн асуудал цахим сургалт
- Ковид нөхцөлд компанийн өртөг зардал бууруулахад анхаарах зүйлс цахим сургалт
- Харвард МенежМентор сургалтыг танилцуулах “Харвард МенежМентор Интро” сургалт
- МҮХАҮТ-ын ажилтнуудыг чадавхжуулах, салбар танхимын удирдлагуудад “Харвард МенежМентор Интро” сургалт
- Танхимын гишүүн байгууллагуудын захиалгаар “Бараа материалын удирдлага ба нөөцийн удирдлага” сургалт
- Их сэргэлт хийх, шинэ нөхцөл байдал компанийн санхүү хөрөнгө оруулалтыг удирдах “Санхүүгийн хөрөнгө оруулалт” сургалт
- Хөдөлмөрийн хуулийн цогц сургалт
- Судалгааны ерөнхий арга зүйч судлаач сургалт
- Судалгааны арга зүйн судлаач сургалт
- Сэдэвчилсэн болон захиалгат сургалтууд

8. Ковидын үеийн Замын-Үүд боомтын хил нэвтрүүлэх машинуудыг зохицуулах эрхээ ашиглаж авилгалд орооцолдсон байж магадгүй асуудал

Замын-Үүд-Эрээн хотод импортын бараа бүтээгдэхүүний автомашины бөөгнөрөл үүсч, хүнсний бараа бүтээгдэхүүн их хэмжээгээр саатсантай холбоотойгоор Эрээн хотоос хүнсний бүтээгдэхүүн ачих аж ахуйн нэгжүүдийн эрэмбэ дарааллыг тогтооход дэмжлэг үзүүлэх талаар хүсэлтийг ХХААХҮЯ, Авто тээврийн үндэсний төвийн ажил хариуцсан хүмүүсээс 12 дугаар сарын 5-ны өдөр МҮХАҮТ-д тавьсны дагуу танхимын Үзэсгэлэн Яармагийн газарт энэхүү асуудлыг түр хугацаанд хариуцуулан ажилласан бөгөөд дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсэн.

- 12-р сарын 7-ны өдөр ЗТХЯ, ХХААХҮЯ, ГЕГ, АТҮТ, хүнс импортлогч аж ахуй нэгжүүдийн төлөөллүүдийг оролцуулсан цахим хурлыг зохион байгуулж, оролцогч талуудын бүрэлдэхүүнтэй түр ажлын хэсгийг МҮХАҮТ-ын даргын тушаалаар байгуулсан.
- Хүнсний бүтээгдхүүн импортлогчдын холбоотой уулзаж, оруулж байгаа машины квотыг тус холбооны гишүүн болон бусад аж ахуйн нэгжүүдэд хуваарилах талаар ярьж тогтсон.

- Аж ахуйн нэгжүүдийн хүсэлтүүдийг хүлээн авч, ачаа ачуулах ААН-ийн нэрсийг өдөр бүр гарган Авто тээврийн үндэсний төвийн Замын-Үүд дэх салбарт хүргүүлж ажилласан ба 12-р сарын 7-15-ны өдрүүдэд 19 машиныг хилээр нэвтрүүлсэн.
- Монгол улсын шадар сайд Я.Содбаатарын тушаалаар байгуулагдсан Бизнесийн зөвлөх зөвлөлийн уулзалтыг Замын үүд, Алтанбулаг хоёр боомт дээр үүсээд байгаа асуудал, хүндрэлийг шийдвэрлэх, цаашид уг боомтуудаар ачаа тээврийг зохицуулах асуудлаар 12 дугаар сарын 12-ний өдөр зохион байгуулсан. Уг уулзалтын үр дүнд Шадар сайдын тушаалаар Замын үүд-Эрээний боомтоор ачаа тээврийн нэвтрэх чадварыг өсгөх чиглэлээр холбогдох арга хэмжээ авч ажиллах үүрэг бүхий ажлын хэсгийг ГХЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга Н.Анхбаяраар ахлуулан байгуулсан.
- МҮХАҮТанхимаас 2020 оны 12-р сарын 16-нд, 2020 оны 12-р сарын 17-нд нэвтрэх нийт 60 машины дугаар Дорноговь аймгийн Замын-Үүд сумын Автотээврийн салбарт хүргүүлэхдээ 40 машины дугаарыг МҮХАҮТанхимд бүртгүүлсэн ААН, 5 машины дугаарыг Аймгийн онцгой комиссын цохолттой машинд, 15 машины дугаарыг Хүнсний бүтээгдэхүүн импортологчдын холбооноос өгсөн дугаарын дагуу илгээсэн. Харин 2 машин нь махны экспорт хийх машинаар гарсан тул дахин 2 машины дугаарыг жагсаалтаас сольж өгсөн. МҮХАҮТ-аас явуулсан нийт 60 машины 51 машин нь жимс, нарийн ногоо, 3 машин хөлдөөсөн тахианы мах, 2 машин шингэрүүлсэн хий, 4 машин нь хүнсний үйлдвэрийн сав баглаа боодол ачихаар орсон.

МҮХАҮТ-ын зүгээс Замын Үүд-Эрээний боомтоор ачаа тээвэрлэхтэй холбоотой асуудал дээр цөөн хоног оролцсон бөгөөд үүссэн нөхцөл байдлын улмаас үргэлжлүүлэн оролцох боломжгүй талаар холбогдох байгууллагуудад мэдэгдсэн. *(Хавсралт 3)*

9. Ковидын үеийн “Хүнд нөхцлийн гэрчилгээ” буюу Force majeure-ийн гэрчилгээг өндөр үнээр компаниудад өгч байсан.

МҮХАҮТ-ын үзүүлдэг үйлчилгээнүүдийн үнэ тариф удаан хугацаанд өөрчлөгдөөгүй байсан. Иймээс танхимаас үзүүлдэг хэд хэдэн үйлчилгээнүүдийн үнэ тарифыг өөрчлөх саналыг боловсруулан УЗ-ийн 2020 оны 2 дугаар сарын 6-ны хурлаар танилцуулан дугаар 6 тогтоолоор батлуулсан. Өөрөөр хэлбэл энэхүү тарифын өөрчлөлт нь ковид гарахын өмнө хийгдсэн бөгөөд Ковид-19 цар тахлын үед хөнгөлөлтийг үзүүлж байсан. *(Хавсралт 4)*

10. Танхимын байр

Хяналтын зөвлөлд ирүүлсэн шаардлагад дурьдсанаар 2019 оны байдлаар Танхим маш бага түрээс буюу сард ойролцоогоор 1,0 сая гаруй төгрөг төлдөг байсан, Танхим байрныхаа түрээсийг Төрийн өмчийн хороо /одоогийн нэр нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар/-нд төлөөгүйгээс болж хуримтлагдсан өр төлбөр үүссэн тул Төрийн өмчийн байгууллага танхимаас байрыг нь хурааж авах хүртэл асуудал үүсээд байна гэдэг нь ташаа мэдээлэл байна.

МҮХАҮТ-ын барилга нь БНХАУ-ын буцалтгүй тусламжаар “МҮХАҮТ-ын зориулалтайгаар” 2009 онд баригдсан бөгөөд 2011 оны 8 дугаар сарын 31-ний өдрийн 253/2011 тоот Улсын комиссын актаар барилгыг ашиглалтад авч Төрийн өмчид бүртгэгдсэн байдаг.

МҮХАҮТ нь анх Төрийн өмчийн хороо /ТӨХ/-ны 2011 оны 473 тоот тогтоолын дагуу ТӨХ-той 2012 оны 3 дугаар сарын 23-ны өдөр “Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийг ашиглуулах” №2 гэрээг байгуулсан. Уг гэрээний 2.2 заалтад Төрийн өмчийн хороо өмч ашиглагчаас түрээсийн төлбөр авахгүй ба ашиглагч ашиглалтын зардлыг бүрэн хариуцна гэж заасан бөгөөд гэрээг 1 жилийн хугацаатай байгуулсан. Үүнээс хойш 2013, 2014 онуудад гэрээг сунгасан. 2015 оны 3 дугаар сарын 30-ны өдөр 2015/4 тоот Төрийн өөрийн өмчийн ашиглалтын гэрээг 1 жилийн хугацаатайгаар шинэчлэн байгуулсан.

Сүүлийн байдлаар 2021 оны 1 дүгээр сарын 29-ны өдөр “Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийг ашиглуулах гэрээ”-г 3 жилийн хугацаатай буюу 2024 оны 1 дүгээр сарын 29-ний өдөр хүртэл хүчин төгөлдөр гэрээг байгуулсан.

Төрийн Өмчийн Бодлого Зохицуулалтын Газар /ТӨБЗГ/-т Үндэсний Аудитын газраас 2021 оны Санхүүгийн тайланд хийсэн аудитаар МҮХАҮТ-тай ашиглалтын гэрээ бус түрээслэх гэрээ байгуулан ажиллах зөвлөмж өгсөн. Уг зөвлөмжийн хэрэгжилтийг хангах талаар ТӨБЗГ-аас 2022 онд Танхимд удаа дараа албан шаардлага ирүүлсэн.

Энэхүү нөхцөл байдлаас үүдэн МҮХАҮТ нь байрны өмчлөлийн асуудлыг шийдвэрлэж өгөх албан хүсэлтийг 2022 оны 5 дугаар сарын 18-ны өдрийн 01/388, 01/389, 01/390 дугаар албан бичгээр дахин Монгол Улсын Ерөнхий сайд, Сангийн сайд, ТӨБЗГ-т хүргүүлсэн ч тодорхой шийдвэр гаргаж, арга хэмжээ аваагүй. Харин ТӨБЗГ-аас 2023 оны 4 дүгээр сарын 07-ны өдрийн А-1/647 тоот албан бичгээр МҮХАҮТ-тай түрээсийн гэрээ байгуулах албан шаардлагыг дахин ирүүлж, нэг сарын 78,5 сая төгрөг буюу нэг жилийн түрээсийн төлбөрт 942,3 сая төгрөг төлөх нөхцөл гэрээний төслийг ирүүлсэн.

Уг үүсээд буй асуудлыг МҮХАҮТ-ын 2023 оны 3 дугаар сарын 23-ны өдрийн УЗ-ийн хурлаар гишүүдэд танилцуулан, байрны өмчлөлийн асуудлыг УИХ, Засгийн газарт дахин тавихаар хэлэлцэж тогтсоны дагуу 2023 оны 5 дугаар сарын 31-ний өдөр Удирдах зөвлөлийн 75 гишүүний гарын үсэгтэй албан хүсэлтийг УИХ-ын дарга, МУ-ын Ерөнхий сайд, ЗГХЭГ-т хүргүүлсэн. (*Хавсралт 5*)

11. 2018 оны эхний байдлаар танхим 7,5 тэрбум төгрөг буюу 3,0 сая ам.доллартай тэнцэх бэлэн мөнгө банкинд хадгалуулсан байсан нь одоо байгаа юу?

2017 оны жилийн эцсийн тайланд банкин дахь бэлэн мөнгөний хэмжээ харилцах болон кассд 0.5 тэрбум төгрөг, хадгаламжид байршуулсан 7.0 тэрбум төгрөг байсан. 2023 оны 09 сарын 16-ны байдлаар харилцах дансанд 1.9 тэрбум төгрөг мөн хадгаламжид 3.7 тэрбум төгрөг, 1 сая доллар байршуулсан. Нийтэд нь дүгнэвэл өнөөдрийн байдлаар 9.1 тэрбум төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй байна.

2017 оны 12 сарын 31-ны Монгол банкнаас зарласан долларын албан ханш 2417.13 байсан бол 2023 оны 09 сарын 16-ны албан ханш 3465.98 байна.

12. Танхимын байрны заалнуудыг өөрийн компанидаа түрээсэлдэг, арга хэмжээний үеэр катеринг, хоолны үйлчилгээ зэргийг хувийнхаа компаниар хийлгэдэг

Танхимын бүх түрээсийн үйлчилгээ дүрэм журмын дагуу түрээсийн гэрээгээр хийгддэг ба мөн гадны байгууллагаас катеринг, хоолны үйлчилгээ зэргийг авдаггүй болно. Зөвхөн 12 сард шинэ жилийн арга хэмжээг зохион байгуулах мэргэжлийн хоёр өөр компанид багцаар 2 удаа түрээслүүлсэн. МҮХАҮТ-ын удирдлагууд энэ хоёр компанитай холбоо хамааралгүй болно. Шинэ жилийн үеэр багцаар түрээслүүлсэн нь танхим өөрсдөө зохион байгуулах үед гардаг ресторан, аж ахуйн ажилтнуудын хэт ачаалыг бууруулж, их танхимын түрээсийн орлогыг нэмэгдүүлсэн бөгөөд Их танхимын засварт зарцуулсан хөрөнгө оруулалтын ихэнх хувийг нөхөж чадсан.

13. Салбар танхимууд удирдлагаа сонгох буюу МҮХАҮТ-ын Их хуралд санал өгөх эрхгүй

Энэ асуудал өмнөх хоёр их хурлыг дамжин яригдсан асуудал бөгөөд МҮХАҮТ-ын 20 дугаар их хурлын өмнө УЗ-ийн гишүүдээс бүрдсэн дүрмийн ажлын хэсэг болон УЗ-ийн хурал яригдсан нэг гол зарчмын асуудал байсан. Ажлын хэсэг дээр олон удаа ярилцсаны эцэст олонхийн саналаар дүрмийн төсөлд томъёолон оруулсан заалт нь УЗ-өөр дэмжигдэн, Их хурлаар батлагдсан.

МҮХАҮТ-ын дүрмийн 6.6-д “Салбар танхимын гишүүд Их хуралд төлөөлөх ардчиллын зарчмаар оролцох ба үүнийг их хурлын ирцэд тооцох бөгөөд мандатын тоогоор саналын эрхтэй байна” гэж заасан.

14. Танхимын нэр дээр БНХАУ-д газар авсан гэж ажилтнууддаа зарласнаа гишүүддээ зарлаж ил болгоно уу

Цар тахлын үед бүс нутагт болоод дэлхий дахинд үүссэн тээвэр, логистикийн хүндрэлтэй нөхцөл байдлаас шалтгаалан бараа бүтээгдэхүүний нийлүүлэлт тасалдаж, тээврийн үнийн өсөлтийг дагасан бараа, бүтээгдэхүүний үнийн өсөлт олон асуудлыг бий болгосон. Тэр дундаа БНХАУ-ын Тианжин боомт дээр 5000 гаруй монголын чингэлэг хагас жил гаруй саатаж, саатсан ачааг шийдвэрлэх асуудлаар МҮХАҮТ-аас холбогдох газруудад удаа дараа санал тавьж ажиллаж ирсэн.

Цар тахлын хүндрэлтэй үе өнгөрсөн хэдий ч Тианжин боомтод дундаж чингэлэг 45 гаруй хонож, тэр хирээр тээвэрлэлтийн үнэ өсөж, энэ нь аж ахуй нэгжүүдийн зардлыг нэмэгдүүлэх гол хүчин зүйл болсоор байна.

Иймд МҮХАҮТ-ын зүгээс БНХАУ-ын дарга Ши Жиньпиний “Нэг бүс нэг зам” санаачилгын хүрээнд Монгол Хятадын худалдаа эдийн засгийн хамтын ажиллагааг өргөжүүлэх, тэр дундаа тээвэр, логистикийн нөхцөлийг сайжруулах чиглэлээр санал гаргаж, БНХАУ-ын Шандун мужийн Рижяо боомтод Монгол Улс

газар эзэмших санал тавьж, боомтын менежментийг хариуцаж буй Ландбридж групптэй Харилцан ойлголцлын санамж бичгийг байгуулаад байна.

Тус боомт нь хятад улс дахь 10 тэргүүлэх боомтын нэг бөгөөд нүүрсний терминал нь хятад улсад анхдагч задгай тэнгисийн терминал, мөн хамгийн анхны хувийн хэвшлийн менежмент бүхий боомт юм. Тус боомтод Монгол Улс газар эзэмшсэнээр Тианжин төвтэй логистикийн олон асуудлыг шийдвэрлэж, тээврийн эргэлтийг нэмэгдүүлэх, тээвэрлэлтийн хугацаа болон үнийг бууруулах ач холбогдолтой юм.

Боомтод Монгол Улс эзэмших боломжтой газрын хэмжээ, төлбөрийн нөхцөлийн талаарх судалгааг айлын талаас хийж, 2023 оны 10 дугаар сард эцсийн саналыг ирүүлэхээр тохиролцсон болно.

15. МҮХАҮТ-ын нэр дээр Кувейтийн аманд газар авч амины орон сууцны хороолол барьж байна

МҮХАҮТ-аас ажилтнуудын нийгмийн асуудлыг шийдвэрлэх зорилготой хувийн орон сууц бариулж, төлбөрийн уян хатан нөхцлөөр ажилтнуудад олгох төслийг хэрэгжүүлж байна. Уг асуудлыг Удирдах зөвлөлийн хуралд танилцуулж, гишүүд дэмжин тогтоолоор баталгаажуулсан. (*Хавсралт 6*)

Төслийн хүрээнд Богд Хан уулын баруун урд энгэр, Түргэний (Кувейтийн) аманд байрших МҮХАҮТ-ын эзэмшил бүхий 5 га газарт хувийн орон сууц барихаар төлөвлөсөн бөгөөд хууль журмын дагуу шаардлагатай зураг төслүүдийг гаргаж, зөвшөөрлийг авсан болно. Барилгын хувьд байгаль орчинд ээлтэй, ердийн барилгуудаас халаах, хөргөх эрчим хүчийг 90 хүртэл хувиар бага зарцуулдаг, барилгын стандарт нь олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн эко барилга юм. Төслийн талаар анх сонирхсон ажилтнуудад газар дээр нь очиж танилцуулга хийсэн бөгөөд 50 орчим ажилтнууд төсөлд хамрагдахаар хүсэлтээ гаргасан.

МҮХАҮТ-аас тавигдах шаардлага, болзлыг хангах барилгын компаниудыг судалсны үндсэн дээр энергийн алдагдалгүй, байгаль орчинд ээлтэй пассив барилга хийж гүйцэтгэдэг, барилгын угсралт, засвар, засал чимэглэлийн албан ёсны тусгай зөвшөөрөл бүхий, танхимын ажилтнуудад хамгийн сайн нөхцөл санал болгосон компанийг сонгон гэрээ байгуулсан бөгөөд одоогийн байдлаар танхимын 18 ажилтан хамрагдаад байна.

16. Гишүүдийнхээ эрх ашгийг хамгаалахаа больсон

МҮХАҮТ 2019-2023 онуудад 120 гаруй хууль, журам, бодлогын баримт бичигт санал өгч, 90 орчим санал зөвлөмжийг холбогдох байгууллагуудад хүргүүлэн ажилласан ба 20 гаруй мэдэгдэл уриалгыг гарган 120 гаруй уулзалт хэлэлцүүлгийг зохион байгуулсан.

Танхимын бодлогын өмгөөлөл, нөлөөлийн чиглэлээр хийсэн үйл ажиллагааны талаар МҮХАҮТ-ын 2019-2023 оны үйл ажиллагааны тайланд дэлгэрэнгүй тусгасан.

Хөдөлмөрийн тухай хуулийн хувьд хийсэн ажлын товч мэдээлэл: МҮХАҮТ-ын хувьд хөдөлмөрийн хуулийг шинэчлэх зайлшгүй шаардлага байгаа гэж үзэн хөдөлмөрийн хуулийн шинэчлэлийн асуудал дээр сүүлийн жилүүдэд хамтран ажиллаж ирсэн. 2016 оноос Хөдөлмөр Нийгмийн Хамгааллын Яамны ажлын хэсэг, 2018 оноос УИХ-ын чуулган болон Байнгын хорооны хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий дэд ажлын хэсэгт танхимын төлөөллүүд орж ажилласан бөгөөд хуулийн төсөлд ажил бизнесийн эрхлэгчдийн саналыг нэгтгэн өгч, ажлын хэсгийн хуралдаануудад тогтмол оролцож тодорхой саналуудыг тавьж хэлэлцүүлж ирсэн. Хөдөлмөрийн тухай хуулийн төслийн тухайд зарчмын зөрүүтэй асуудлууд болон Хөдөлмөрийн хуульд шинээр тусгагдсан зохицуулалтын талаар УИХ-ын гишүүн, ажлын хэсгийн ахлагч Ц.Мөнх-Оргил, ХНХЯ-ны төлөөллүүдийг оролцуулсан хоёр удаагийн томоохон хэлэлцүүлгийг зохион байгуулсан. Хуулийн төслийн УИХ-ын байнгын хороогоор хэлэлцүүлэх шатанд “Уртын ээлжээр ажиллагсдын ажил амралтын зохимжит хугацааны талаар судалгаа” явуулж үр дүнг хууль тогтоогчдод танилцуулсан бөгөөд хууль хэрэгжиж эхэлсний дараахан 2022 оны 5 сард уртын ээлжийн талаар уул уурхайн хэд хэдэн компаниас асуумж явуулсан. 2023 оны 4 сард “Хөдөлмөрийн хууль тогтоомжийн шинэчилсэн зохицуулалтын үр нөлөө, тулгамдаж буй асуудлууд” сэдэвт хэлэлцүүлгийг зохион байгуулсан ба уулзалт дээр гарсан саналуудыг нэгтгэн УИХ-ын Нийгмийн бодлогын байнгын хороо, Хөдөлмөр нийгмийн хамгааллын яаманд хүргүүлээд байна.

Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулга, Нийгмийн даатгалын багц хуулийн төсөлд хүргүүлсэн зарим саналууд болон уртын ээлжээр ажиллагсдын ажил, амралтын зохимжит хугацааны судалгааг хавсаргав. (*Хавсралт 7*)

2019-2023 онуудад гаргасан уриалга мэдэгдлийн жагсаалт

- a. Бизнесийнхэн хамтдаа хүндрэлийг даван туулах уриалга
- b. Бизнесийг түр хаасан онцгой нөхцөл байдлыг хүлээн авах талаар уриалга
- c. Бизнесийг хамгаалах, ажлын байрыг хадгалах чиглэлээр багц арга хэмжээ бүхий саналуудыг яаралтай хэрэгжүүлж эдийн засаг, бизнест учрах эрсдэлийг буруулах, хохирол багатай даван туулах цогц арга хэмжээг цаг алдалгүй авах нэн шаардлагатай талаар Бизнесийн холбоод, ТББ-ууд хамтарсан мэдэгдэл
- d. Бизнесийн бодлого хууль эрх зүйн орчныг таатай болгох, бодлогын тогтвортой байдлыг хадгалах, цар тахлын улмаас үүссэн хүндрэлтэй нөхцөл байдлыг богино хугацаанд даван туулах, эдийн засгийг сэргээх, эрчимжүүлэх чиглэлээр шинэ Засгийн газарт хүргэх санал зөвлөмжийг гаргах талаар ТОП-ААН-үүд хамтарсан мэдэгдэл
- e. “Монголын Ноосон Бүтээгдэхүүн Үйлдвэрлэгчдийн Холбоо”-той хамтран Монгол Улсын Засгийн Газар, хөгжлийн түнш байгууллагуудыг ноос бэлтгэлийн ажлыг шинэчлэхэд илүү их хөрөнгө оруулалт оруулахыг уриалга
- f. Бизнесийнхэн хамтдаа хүндэрлийг даван туулах уриалга
- g. Бизнес эрхлэгчиддээ хандан дархлаажуулалтын нэмэлт тунд хамрагдах уриалга
- h. Хүнд нөхцөл байдалд гэрээний зарим нөхцөлд тохируулга хийх тухай Төрийн өмчит аж ахуйн нэгж, байгууллагуудад хандсан уриалга

- i. “Автотээврийн хэрэгслийн эзэмшигчийн хариуцлагын даатгалын тухай хууль”-ийн төсөлтэй холбоотой мэдэгдэл
- j. Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэнгийн бизнес эрхлэгчдийн хэлсэн үгтэй холбогдуулан уучлал гуйх хариуцлага тооцох тухай шаардлага
- k. МҮХАҮТ-аас Төрийн өмчит аж ахуйн нэгж, байгууллагуудад хандан уриалга
- l. МУХБ-аас олгосон зээлүүдийг ул суурьтай судлан дүгнэх, олон нийтэд үнэн зөв мэдээлэл хүргэх, шүүх хяналтын байгууллагууд нь шударгаар ажиллаж зээл тойрсон асуудлуудын үнэн мөнийг тогтоон шийдвэрлэх талаар мэдэгдэл
- m. Татварын өртэй ААН-үүдийн татварыг хөнгөлөх, төлөх, хугацааг сунгах асуудлаар танхимын байр суурийг илэрхийлсэн мэдэгдэл
- n. Хуш модны самар экспортлогчдоос зүй бус төлбөр төлөхийг шаардсан хэмээн хэвлэл, мэдээллийн хэрэгслээр танхимын тухай гарсан мэдээлэл нь үндэслэлгүй болох талаар мэдэгдэл
- o. Монгол Улсын Засгийн Газраас ноолуур, арьс ширний техникийн зохицуулалтын хэрэгжилтийг тодорхой хугацаагаар хойшлуулах, цуцлахаар яригдаж байгаатай холбоотой мэдэгдэл (*Хэвсралт 7*)

17. Гишүүд ЖДҮ-үүдийг хаясан

“Монгол Хятадын Хөх хотын анхдугаар удаагийн ЭКСПО” Хөх хотод ЭКСПО 2015 онд Аж үйлдвэрийн яам нь МҮХАҮТ-нд бүрэн эрхийг нь өгч ажилласан. 230 ААН-д зохион байгуулж оролцуулсан.

2017 онд “Монгол Хятадын Хөх хотын 2 удаагийн ЭКСПО” Монголын талаас ХХААХҮЯ ерөнхий зохион байгуулагчаар ажиллаж МҮХАҮТанхим, МҮДХолбоо, Мишээл Экспо хамтран зохион байгуулагчаар ажиллаж байсан. Тухайн үед хилээр сүү цагаан идээ, мах махан бүтээгдэхүүнийг оруулахаар яригдаж байсан боловч эцсийн мөчид Хятадын тал оруулахгүй шийдвэр гаргаж бүх мах сүү цагаан идээ Монголд буцаж ирж усгалд орж байсан. ХХААХҮЯ, МҮХАҮТанхим удаа дараа Хөххотын үзэсгэлэнг зохион байгуулах хороотой уулзалт хийсний хүчинд устгагдсан мах сүүний ААН-дийн хохирлыг барагдуулсан. Бусад ААН бараа бүтээгдэхүүнээ борлуулж амжилттай оролцсон.

2019, 2023 онд Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Жижиг дунд үйлдвэрийн газар ерөнхий зохион байгуулагчаар ажиллаж МҮХАҮТ, МҮДХ, Мишээл Экспо ХХК хамтран гүйцэтгэгч байгууллагаар ажиллаж үзэсгэлэн худалдааг Улаанцав болон Хөххотод амжилттай зохион байгуулсан.

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Жижиг дунд үйлдвэрийн газар нэг байгууллагад давуу эрх олгохгүйгээр үзэсгэлэн зохион байгуулагч байгууллагуудад ижил тэгш эрхийн хүрээнд зохион байгуулалтыг хариуцуулсан явдал бөгөөд энэ үндэслэлээр Мишээл экспо оролцож байгаа болно.

18. Өмнө нь Танхим бие даан хийдэг байсан судалгаануудыг хийхээ больсон

2019-2023 онд МҮХАҮТ-аас бизнесийн салбарын бодлогын өмгөөлөл нөлөөллийн үйл ажиллагааг шинжлэх ухааны үндэслэлтэй, мэргэжлийн өндөр түвшинд явуулан, судалгаа өгөгдөлд үндэслэсэн бизнесийн орчинтой холбогдох

оновчтой бодлого шийдвэр гаргахад дэмжлэг үзүүлэх зорилгоор 2021 оны 1 сарын 27-ний өдрийн Тэргүүлэгчдийн тогтоолоор Эдийн засгийн судалгааны институтийг байгуулж төрийн, олон улсын болон мэргэжлийн холбоод, төрийн бус байгууллагуудтай бизнесийн орчны судалгаа шинжилгээ хийж хамтран ажиллаж байна.

МҮХАҮТ-аас энэхүү хугацаанд тогтмол болон цаг үеийн бизнес эдийн засгийн орчинтой холбогдох 40 гаруй судалгаа шинжилгээ, үнэлгээ хийсэн байна. Мөн Судалгааны институт нь дотоодын болон гадаадын аж ахуйн нэгжүүдийн захиалгаар Монгол улсын тухайлсан бараа бүтээгдэхүүний зах зээлийн судалгааг хийж гүйцэтгэж байна.

Тогтмол болон цаг үеийн шаардлагаар хийсэн гол судалгаануудын мэдээлэл, тайлангийн цахим холбоосны хамт хүргүүлж байна. Мөн зарим судалгааны хэвлэмэл тайланг хавсаргав.

МҮХАҮТ-аас Монголын бизнесийн орчны өөрчлөлт, түүний үр нөлөөг тогтмол ажиглан судлах холбогдох санал, зөвлөмж боловсруулах зорилгоор 3 төрлийн судалгааг тогтмол хийж байна.

Монголын бизнесийн орчны судалгаа: Энэхүү судалгааг МҮХАҮТ, МУИС-ын Бизнесийн сургуультай хамтран 2017 оноос эхлэн 3 жил тутамд хийдэг ба Монгол улсын бизнесийн орчинд тохирсон асуулга аргачлалаар боловсруулсан, үндэсний хэмжээний тогтмол хийгддэг судалгаа юм. Бизнесийн орчныг эдийн засаг, засаглал хууль эрх зүй, дэд бүтэц технологи, нийгэм соёл, байгууллагын дотоод орчин гэсэн ерөнхий 5 үзүүлэлт, дэд 12 үзүүлэлтээр үнэлдэг.

2020 оны судалгаагаар Монголын бизнесийн орчны ерөнхий үнэлгээ нь 2.91 буюу дунд гэж үнэлэгдсэн нь 2017 оноос бизнесийн орчин сайжирсан гэсэн үр дүн юм. Мөн 2023 оны бизнесийн орчны судалгааг Улаанбаатар хот, 21 аймгийн 5000 гаруй бизнес эрхлэгчдээс судалгааны мэдээлэл цуглуулж, үр дүнг боловсруулах ажил хийгдэж байна.

2020 онд ЕХ-ны Монголын худалдааг дэмжих төсөл (TRAM)- с санхүүжүүлэн судалгааг хийж гүйцэтгэсэн ба МҮХАҮТ-аас МУИС-д судалгааны ажил хийж гүйцэтгэхтэй холбоотой ямар нэгэн төлбөр төлөөгүй болно.

Судалгааны тайлангууд:

- Монголын бизнесийн орчны судалгаа-2017
<https://www.mongolchamber.mn/p/75>
- Монголын бизнесийн орчны судалгаа-2020-
<https://www.mongolchamber.mn/p/365>

Хүнд суртлын индекс судалгаа: МҮХАҮТ-аас 2004 оноос эхлэн хоёр жил тутамд явуулдаг ба бизнес эрхлэгчид төрийн үйлчилгээ авахад тулгарч буй бэрхшээл, хүнд суртлыг үнэлэх судалгааны үр дүнд үндэслэн төрийн үйлчилгээний хүнд суртлыг бууруулах чиглэлд санал, зөвлөмж гаргах зорилготой судалгаа юм.

2018 онд хүнд суртлын индексийг илүү бодитой тооцох зорилгоор Азийн сантай хамтран олон улсын туршлагын дагуу аргачлал, асуулгыг шинэчилсэн. Ингэхдээ төрийн ба орон нутгийн захиргааны байгууллагаас бизнес эрхлэгчдийн түгээмэл

авдаг үйлчилгээний мэдээллийн санг үүсгэн, үйлчилгээ бүрийг бизнес эрхлэгчдээр үнэлүүлэхийг зорьсон бөгөөд үүний дүнд төрийн 54 байгууллагын давхардсан тоогоор 2009 үйлчилгээ үнэлэгдсэн юм.

МҮХАҮТ-ын Хүнд суртлын индекс судалгаа нь 2022 оны 6 сард батлагдсан Зөвшөөрлийн тухай хуулийн суурь судалгаа болсон.

Судалгааны тайлангууд:

- Хүнд суртлын индекс-2018- <https://www.mongolchamber.mn/p/77>
- Хүнд суртлын индекс-2021- <https://www.mongolchamber.mn/p/385>

Бизнесийн итгэлийн индекс судалгаа: Монголын бизнесийн орчны өөрчлөлт, бизнес эрхлэгчдийн дараа жилд итгэх итгэлийг хэмжих зорилгоор Бизнесийн итгэлийн индекс судалгааг МҮХАҮТ-аас 2001 оноос хойш тасралтгүй жил бүр хийж байна. Энэхүү судалгаа нь өмнө нь “Бизнес итгэлийн индекс” нэртэй боловч ямар нэг индекс тооцдоггүй байсан ба олон улсын бизнесийн судалгаа хийдэг аргачлалыг судлан, тохирох аргачлалыг боловсруулан индекс тооцдог болгосон.

Судалгааны тайлангууд:

- Бизнес итгэлийн индекс-2019- <https://www.mongolchamber.mn/p/73>
- Бизнес итгэлийн индекс-2020- <https://www.mongolchamber.mn/p/361>
- Бизнес итгэлийн индекс-2021-2022- <https://www.mongolchamber.mn/p/386>

Монголын бизнесийн орчны өөрчлөлт, бизнес эрхлэгчдэд тулгарч буй тодорхой асуудлуудаар санал, зөвлөмж боловсруулах зорилгоор МҮХАҮТ-аас цаг үеийн холбогдох судалгаа шинжилгээг хийж, үр дүнг боловсруулан ажиллаж байна. Онцлох судалгааг дурдвал МҮХАҮТ, ҮСХ-той хамтран экспортлогч аж ахуйн нэгжүүдийг бүрэн хамруулсан экспортлогчдын өнөөгийн нөхцөл байдал, экспорт хийхэд тулгарч буй бэрхшээл, шаардлагатай дэмжлэгийг тодруулсан анхны судалгааг 2022 онд хийв. Түүнчлэн 2021 оноос эхлэн МҮХАҮТ-ийн Эдийн засгийн судалгааны институтын саналаар Монгол улсад анх удаа аж ахуйн нэгж байгууллагын тооллогоор экспортлогч аж ахуйн нэгжүүдийг тоолдог болсон билээ. (Судалгааны тайлан- <https://www.mongolchamber.mn/a/1301>)

Цаг үеийн судалгаанууд:

- Монгол улсын ноолуурын зах зээлийн мэдээлэл, чиг хандлага (2021)
- “Инфляцийн хүлээлтийн судалгаа”- (Монгол банктай хамтарсан, 2021-2022)
- Экспортын гол нэрийн түүхий эдийн нэр төрлийн судалгаа (2021)
- Өндөр насны тэтгэвэр авагчийн өнөөгийн нөхцөл байдлын судалгаа (2021)
- Их сэргэлт санаачилгын судалгаа (2021)
- 3 хувийн зээлийн хүртээмжийн судалгаа (2021)
- Улаанбаатар хотын замын түгжрэлийг бууруулах зорилгоор бараа түгээлтийн тээврийн хэрэгслийг шөнийн цагаар явуулбал худалдаа, үйлчилгээний байгууллагууд болон үйлдвэрлэгч, нийлүүлэгч, сүлжээ дэлгүүрүүдэд хэрхэн нийцэх тухай судалгаа (2021)
- Монгол Улс, БНСУ хооронд эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр (ЕРА) байгуулахыг бизнес эрхлэгчид хэрхэн дүгнэж буй талаар судалгаа (2021)

- Аялал жуулчлалын салбарын бизнес эрхлэгчдэд үзүүлж буй цар тахлын нөлөө судалгаа (2022)
- Барилгын материалын үнийн судалгаа (2022)
- Хотын төвлөрлийг сааруулахад топ аж ахуйн нэгжүүдэд тулгарч буй бэрхшээл, шаардагдах дэмжлэг торуулах судалгаа (2022)
- Компани анх удаа хувьцаагаа олон нийтэд санал болгох (IPO) үйл ажиллагаатай холбогдох бизнес эрхлэгчдийн судалгаа (Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн бирж, Улаанбаатар үнэт цаасны бирж хамтарсан, 2022)
- Татварын өр төлбөртэй холбоотой хүндрэл, нөхцөл байдлын судалгаа (2022)
- Уул уурхайн бус экспортлогчдын түүвэр судалгаа (Монголбанкттай хамтарсан, 2022)
- Олон Улсын үйлдвэрлэгчийн үнийн индекс, Монгол Улсын индекстэй харьцуулсан судалгаа (2022)
- Зөгийн балны кластерийн судалгаа (2022)
- МҮХАҮТ-ын үйлчилгээний гишүүн болон гишүүн бус бизнес эрхлэгчдийн сэтгэл ханамжийн судалгаа (2022)
- Монгол Улсын Экспортлогч аж ахуйн нэгжүүдийн нөхцөл байдал сэдэвчилсэн судалгаа (Үндэсний сатистикийн хороотой хамтарсан, 2023)
- "Ургамлын аргаар идээлүүлсэн сарлагийн арьс шир ба арьсан бүтээгдэхүүний кластерийн гишүүдийн хэрэгцээ шаардлагын үнэлгээ" судалгаа (SWITCH ASIA хөтөлбөрийн хүрээнд, 2023)
- Монгол улсын нүүрс тээврийн нөхцөл байдлын судалгаа (2023)
- Худалдааны санхүүжилтийн нөхцөл байдлын судалгаа (2023)

Цар тахлын нөлөөгөөр аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаа бүр болон түр хугацаагаар зогсох буюу хязгаарлагдсан, цар тахлын дараа олон улсын харилцаа гадаад худалдааны тодорхойгүй, тааламжгүй орчин нөхцөлд бизнес эдийн засгаа сэргээхэд бизнес эрхлэгчдэд тулгарч буй бэрхшээл, хэрэгцээтэй дэмжлэгийг тодруулж бодит судалгаа, мэдээлэлд үндэслэсэн оновчтой гарц шийдэл тодорхойлох зорилгоор шаардлагатай судалгаа шинжилгээг үе шаттайгаар хийж ажилласан. Судалгааны үр дүнг тухай бүрд төр засагт шуурхай хүргүүлж ажилласан бөгөөд эдгээр судалгааны үр дүн мэдээлэлд үндэслэн УИХ, Засгийн газраас тодорхой шийдвэрүүд шат дараалан гарч үр дүнгээ өгсөн билээ.

Цар тахлын үеийн судалгаанууд:

- COVID-19: Бизнес үзүүлж буй нөлөөний судалгаа (2020, 3 сарын 5)
- COVID-19: Түрээсийн бизнест үзүүлж буй нөлөөний судалгаа (2020, 3 сарын 5)
- COVID-19: Ажлын байрны нөлөөний судалгаа (2020, 3 сарын 20)
- COVID-19: Эм хангамжийн салбарт үзүүлж буй нөлөөний судалгаа (2020, 3 сарын 20)
- Улаанбаатар хотын цар тахлын бизнес нөлөөний судалгаа (2020, 3 сарын 5)
- Ажлын байрнаас хамаарах иргэдийн орлогын өөрчлөлтийн судалгаа (2020, 4 сарын 20)
- Хатуу хөл хорионы үеийн хувиараа бизнес эрхлэгчдийн нөхцөл байдал судалгаа (2020, 11 сарын 25)

- Бизнесээ сэргээхэд бизнес эрхлэгчдэд тулгарч буй хүндрэл, шаардагдах дэмжлэг тодруулах судалгаа (2021, 9 сарын 3)
- Цар тахлын дараах бизнесийн нөхцөл байдлын судалгаа (2022, 9 сарын 4)
- Цар тахлын дараах иргэдийн орлогын өөрчлөлтийн асуумж (2022, 11 сар)

Судалгааны тайлангуудыг дараах холбоосоор татаж үзэх боломжтой.

- COVID-19: Бизнес үзүүлж буй нөлөөний судалгаа (2020, 3 сарын 5)- (нэгдсэн тайлан- <https://www.mongolchamber.mn/p/328>)
- COVID-19: Түрээсийн бизнест үзүүлж буй нөлөөний судалгаа (2020, 3 сарын 5) (нэгдсэн тайлан- <https://www.mongolchamber.mn/p/328>)
- COVID-19: Ажлын байрны нөлөөний судалгаа (2020, 3 сарын 20) (нэгдсэн тайлан- <https://www.mongolchamber.mn/p/328>)
- COVID-19: Эм хангамжийн салбарт үзүүлж буй нөлөөний судалгаа (2020, 3 сарын 20)- (нэгдсэн тайлан- <https://www.mongolchamber.mn/p/328>)
- Ажлын байрнаас хамаарах иргэдийн орлогын өөрчлөлтийн судалгаа (2020,4 сарын 20) - <https://www.mongolchamber.mn/p/368>
- Хатуу хөл хорионы үеийн хувиараа бизнес эрхлэгчдийн нөхцөл байдал судалгаа (2020, 11 сарын 25)- <https://www.mongolchamber.mn/p/364>
- Бизнесээ сэргээхэд бизнес эрхлэгчдэд тулгарч буй хүндрэл, шаардагдах дэмжлэг тодруулах судалгаа (2021, 9 сарын 3)- <https://www.mongolchamber.mn/p/369>
- Цар тахлын дараах бизнесийн нөхцөл байдлын судалгаа (2022, 9 сарын 4)- <https://www.mongolchamber.mn/p/382>

МҮХАҮТ-ын Судалгааны институтээс хийж гүйцэтгэсэн бусад судалгааны тайлантай танилцах холбоос- <https://www.mongolchamber.mn/p?c=7>

19. Танхимын дүрэмд өөрчлөлт оруулах

МҮХАҮТ-ын дүрмийн нэмэлт өөрчлөлтийн оруулахын тулд Их хурлаас 2-3 сарын өмнө дүрмийн Удирдах Зөвлөлийн гишүүдээс бүрдсэн дүрмийн ажил хэсэг байгуулагдан ажиллаж, МҮХАҮТ-ын дүрмийн 7.10.6-д заасны дагуу дүрмийн төслийг УЗ-ийн хурлаар зүйл тус бүрээр хэлэлцэн Их хуралд оруулах асуудлыг шийдвэрлэдэг. МҮХАҮТ-ын дүрмийн 6.3-т заасны дагуу Удирдах зөвлөл 8 дугаар сарын 10-нд хуралдан 21 дүгээр Их хурлын өдрийг 2023 оны 9 дүгээр сарын 20-ны өдөр товлож, хэлэлцэх асуудлын төлөвлөгөөг баталсан билээ.

Гомдолд дурдсан танхимын үйл ажиллагаатай холбоотой асуудлын талаар дэлгэрэнгүй мэдээллийг МҮХАҮТ-ын 2019-2023 оны үйл ажиллагааны тайлангаас авах боломжтой. Эцэст нь хэн нэгний сонгох сонгогдох эрхийг хууль эрх зүйн ямар нэг үндэслэлгүйгээр хориглох боломжгүйг анхаарахыг хүсье.

Хавсралт: 168 хуудас

Хүндэтгэсэн,

ЕРӨНХИЙЛӨГЧ

О.АМАРТҮВШИН